



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 16 өдөр


Дугаар А/586

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт явуулахад шаардагдах хөрөнгийг тухай бүр Эрүүл мэндийн яамны төсөвт суулган санхүүжүүлж байхыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.
3. Журмын биелэлтэнд хяналт тавьж, мөрдөж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн А/295 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



141202398

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 12 сарын 16-ний өдрийн  
дугаар тушаалын Хавсралт

2/586

## ДОТООД АУДИТ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн (цаашид Төсвийн ерөнхийлөн захирагч гэх) дэргэдэх Дотоод аудитын нэгжийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалттай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаандаа төсөв, санхүү, аудитын холбогдолтой Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, дүрэм, журам, гэрээ, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, холбогдох тушаал, шийдвэр болон энэхүү журмыг удирдлага болгон мөрдөж ажиллана.
- 1.3 Дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална.

### Хоёр. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

Дотоод аудитын нэгж нь Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гэсэн хоёр үндсэн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

#### 2.1 Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитыг дараах чиг үүргийн хүрээнд хийнэ. Үүнд:

- 2.1.1 Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хэрэгжилтийн хяналт
- 2.1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал
- 2.1.3 Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, их засварын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, явц, үр дүн
- 2.1.4 Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүн
- 2.1.5 Салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдал
- 2.1.6 Байгууллагын дотоод хяналт, засаглалын байдалд болон холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит
- 2.1.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлан явуулах дотоод аудит



## **2.2 Санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа**

Санхүүгийн хяналт шалгалтыг дараах чиг үүргийн хүрээнд хийнэ. Үүнд:

- 2.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан
- 2.2.2 Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаа
- 2.2.3 Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалт
- 2.2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, тайлан, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрт хийсэн хөндлөнгийн аудитын зөвлөмж, шаардлагын хэрэгжилт, явц, үр дүн
- 2.2.5 Эрүүл мэндийн яамны аппаратын үндсэн болон нэмэлт дансны тайланд хийсэн хөндлөнгийн аудитын зөвлөмж, шаардлагын хэрэгжилт, явц, үр дүн
- 2.2.6 Шилэн дансны хуулийн хэрэгжилт
- 2.2.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлан явуулах санхүүгийн хяналт шалгалт

### **Гурав. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөх**

#### **хэрэгжүүлэх үе шат**

- 3.1 Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөөг жилээр боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.
- 3.2 Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудит, санхүүгийн хяналт шалгалтын удирдамжийг нэгдсэн байдлаар эсвэл тухай бүрт батлуулж, мөрдөж ажиллана.
- 3.3 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хяналт шалгалтад хамрагдах байгууллагын цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, баримт материалын байдлыг харгалзан аудитыг гүйцэтгэх, хамтран ажиллах нөөц гишүүдийн тоог тогтооно.
- 3.4 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад зарцуулах хугацааг дараах байдлаар тооцно. Үүнд:
  - 3.4.1 Нийт урсгал зардлын хэмжээ эсвэл хөрөнгө оруулалтын хэмжээ 1,000.0 сая төгрөг хүртэл бол ажлын 14 хоног
  - 3.4.2 Нийт урсгал зардлын хэмжээ эсвэл хөрөнгө оруулалтын хэмжээ 1,000.0-5,000.0 сая төгрөг хүртэл бол ажлын 18 хоног
  - 3.4.3 Нийт урсгал зардлын хэмжээ эсвэл хөрөнгө оруулалтын хэмжээ 5,000.0-с дээш төгрөг бол ажлын 20 хоног



- 3.5 Жилийн төлөвлөгөөний дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг явуулахдаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг, даалгавар, аудитын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэнэ.
- 3.6 Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, тайланг бэлтгэн нэгжийн даргад танилцуулах ба шийдвэр зөвлөмжийг аудитад хамрагдсан байгууллага, нэгжид хүргүүлнэ.
- 3.7 Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалтаар тогтоогдсон акт, албан шаардлага, зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана.

#### **Дөрөв. Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын нотолгоо**

- 4.1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажилтан нь ажлын эцсийн тайлан, дүгнэлт гаргахад шалгалтаар илэрсэн алдаа дутагдал болон бусад зүйлүүдийн баримтаар нотлох ба нотолгоо нь хуулийн дагуу үнэн зөв, дүгнэлт шийдвэр гаргахад хангалттай хүрэлцэхүйц байна.
- 4.2 Байгууллагын болон нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн нь байгууллагын өмнөө тавьсан зорилтоо биелүүлээгүй шалтгааны үндэс болсон эсэхийг хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа ажилтан тодруулан тогтооно.
- 4.3 Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх явцад ажлын баримт нотолгоо, түүний илрэн гарч байгаа учир шалтгааныг тогтоохдоо дараах дарааллаар хийж гүйцэтгэнэ.
  - 4.3.1. Хяналт шалгалтын болон тухайн байгууллагын аудитад хамрагдах үеийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах
  - 4.3.2. Олж цуглуулсан мэдээллүүдийг үйл ажиллагааны хамрах цар хүрээ, хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа хугацаагаар нь ангилалт хийх
  - 4.3.3. Ангилалт хийсэн мэдээллийг боловсруулах.

#### **Тав. Шалгалтын үр дүнг танилцуулах, мэдээлэх**

- 5.1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгавар болсны дараа шалгалтын тэмдэглэл үйлдэн, үр дүнгийн талаарх гол мэдээллүүдийг багтаасан тайланг бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна
- 5.2 Тайлан болон нэг бүрчилсэн актыг эцсийн байдлаар гаргахдаас өмнө дүгнэлт болон зөвлөмжийн талаар Нэгжийн даргад танилцуулж, зөвшилцсөн байна.
- 5.3 Шалгалтын тэмдэглэл, тайлан, нэг бүрчилсэн акт нь утга агуулгатай, ойлгоцтой, товч тодорхой байна.
- 5.4 Аудитын тайланд шалгалтын зорилго, цар хүрээ, үр дүнг тодорхой харуулж илтгэсэн байх бөгөөд шаардлагатай тохиолдолд дотоод аудитор, улсын /ахлах/ байцаагчийн санал дүгнэлтийг тусгасан байна.
- 5.5 Аудитын тайлан, шалгалтын тэмдэглэлд төлбөр, зөрчлийн жагсаалт, нэг бүрчилсэн акт, захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэвэр, хяналт шалгалтанд оролцсон холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт, бусад холбогдох материалыг хавсаргасан байна.

- 5.6 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг удирдамжийн хүрээнд гүйцэтгэж, тайланд тухайн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үнэлэлт, дүгнэлтийг дурьдахын зэрэгцээ, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, цаашид авах арга хэмжээ, учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг асуудлаар хугацаа заасан үүрэг, зөвлөмж бүхий албан тоотыг шалгагдсан байгууллагад өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
- 5.7 Санхүүгийн баримтын шалгалтаар гэмт хэргийн шинжтэй зөрчил илрүүлсэн тохиолдолд акт материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

### **Зургаа. Маргаан гарах, түүнийг шийдвэрлэх**

- 6.1 Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалттай холбогдон гарсан маргааныг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж гомдол гаргасан этгээдэд хариу хүргүүлнэ.

ооооо